



ОНЦГОЙ БАЙДЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай

Улсын хэмжээнд 2023 онд Архангай, Баянхонгор, Булган, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл Баян-Өлгий, Увс, Хэнтий, Завхан, Говьсүмбэр, Өвөрхангай зэрэг 14 аймгийн 42 суманд 101 удаагийн ой, хээрийн гал түймэр буртгэгдсэн. Ой, хээрийн гал түймрийн дуудлагын тоог 2022 оны мөн үетэй харьцуулахад 43 хувиар буурсан.

Дээрх түймэрт 10 хүн түлэгдэж, 40 гэр, байшин (сууц), 71 хашаа (саравч), 9 автомашин, 7,931 мал, 148 ан амьтан, ойн 1,296 га, хээрийн 3,079,274га, нийт 3,080,570 га талбай өртөж байгаль экологид 16,7 тэрбум, эд материалын 6,2 тэрбум, гал түймрийг унтраахад 103,7 сая төгрөг зарцуулж, нийт 23,1 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

ОХУ-ын талаас Монгол Улсын хил дамнан Дорнод аймгийн Чулуунхороот, Увс аймгийн Тэс, Сагил, Сэлэнгэ аймгийн Ерөө сумдын нутгаар тус бүр нэг удаа нийт 4 удаа хээрийн түймэр орж ирсэн.

Монгол Улсын талаас ОХУ-ын тал руу Дорнод аймгийн Чулуунхороот, Дашбалбар, Увс аймгийн Сагил сумын нутгаар нийт 4 удаа хил дамнан гарсан.

Монгол Улсын талаас БНХАУ-ын тал руу Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Чулуунхороот, Халхгол, Баянтүмэн, Чойбалсан, Матад сумын нутгаар нийт 9 удаа хээрийн гал түймэр дамнан гарсан.

Ой, хээрийн гал түймрийг унтраах ажиллагаанд Онцгой байдлын байгууллагын 1284 алба хаагч, 125 автомашин, Хил хамгаалах байгууллагын 485 алба хаагч, 62 автомашин, 2 морь, Зэвсэгт хүчний 52 алба хаагч, 3 автомашин, 2 нисдэг тэрэг, Цагдаагийн байгууллагын алба 10 хаагч, 3 автомашин, орон нутгаас 3142 иргэн, 492 автомашин, 1 трактор, 91 мотоцикл, 18 морь, нийт 4973 хүн, 685 автомашин, 3 нисдэг тэрэг, 1 трактор, 91 мотоцикл, 20 морьтой ажилласан.

Цаг уур, орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын урьдчилсан мэдээллээр агаарын дундаж температур 3, 4 дүгээр сард нутгийн баруун хэсгээр олон жилийн дунджаас дулаан, Сэлэнгэ, Төв, зүүн аймгуудын нутгаар дунджаас хүйтэн, бусад нутгаар дундаж орчим, 5 дугаар сард нийт нутгаар дунджийн орчим байх ба хур тунадас 4 дүгээр сард төв болон зүүн аймгуудын нутаг, Дундговь, Дорноговийн ихэнх нутгаар дунджаас ахиу, 3, 4 дүгээр сард баруун аймгуудын нутгаар дунджаас бага, бусад хугацаанд дунджийн орчим байх төлөвтэй байна.

Иймд Улсын Онцгой комиссын 2024 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврын

142410003

хэрэгжилтийг хангуулах, ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг. Гал түймэртэй тэмцэх газрын дарга,
хурандаа Ц.Нямбаярт

1.1. Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, нөхцөл байдлыг үнэлж, нэмэлтээр хүн хүч ажиллуулах арга хэмжээг шуурхай зохион байгуулж, нөхцөл байдлын талаар танилцуулахыг;

1.2. Хил орчим болон алслагдсан бүс нутагт гарсан ой, хээрийн гал түймрийн голомтод автомашинтай очих боломжгүй тохиолдолд Зэвсэгт хүчний болон Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийн нисдэг тэргээр тусгай үүргийн нислэг үйлдэж, хүн хүчийг хүргэх, тээвэрлэх талаар саналыг танилцуулж, шийдвэрлүүлэхийг;

1.3. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд түймрийн голомтод холбогдох албан тушаалтныг томилж удирдлага, зохион байгуулалтаар хангуулахыг;

1.4. Ой, хээрийн гал түймрийн эрсдэлтэй бүс нутагт үйл ажиллагаа эрхэлдэг айл өрх, амралтын газар, жуулчны бааз, мод, хадлан бэлтгэх бүлэг нөхөрлөл зэрэг иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламж, үйл ажиллагаанд гал түймрийн улсын хяналт шалгалтыг зохион байгуулах удирдамжийг батлуулах, хяналт шалгалт зохион байгуулж, зөрчлийг арилгуулах ажиллагаанд хяналт тавихыг;

Хоёр. Эрсдэлийн удирдлагын газрын дарга,
хурандаа Д.Баасансүрэнд

2.1. Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газартай хамтран хийх, хяналт тавих, мэргэжлийн удирдлага, зөвлөмжөөр хангахыг;

2.2. Ой, хээрийн гал түймрийн ерөнхий үнэлгээний үр дүнд үндэслэн их болон маш их эрсдэлтэй нутаг дэвсгэрт нарийвчилсан үнэлгээг нутгийн захиргааны байгууллагатай хамтран мэргэжлийн байгууллагаар хийлгэж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зөвлөмж гаргахыг;

Гурав. Урьдчилан сэргийлэх газрын дарга,
хурандаа Ц.Уранчимэгт

3.1. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхийг;

3.2. Урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээ мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөөг бүх төрлийн мэдээллийн сувгаар олон нийтэд хүргэж, иргэдэд чиглэсэн нөлөөллийн аян зохион байгуулахыг;

3.3. Гамшгаас хамгаалах, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн бүрэлдэхүүн болон иргэдэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийн үед амь нас, эд хөрөнгөө хамгаалах, гал түймэр унтраах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт, дадлага зохион байгуулахыг;

3.4. Ой, хээрийн гал түймрийн эрсдэлтэй бүс нутгийн хуурайшилтын зэрэг, төлөв байдлын мэдээг тогтмол, гал түймэр гарсан газар орны цаг агаарын нарийвчилсан мэдээг тухай бүр гаргаж холбогдох бүтцийн нэгжид хүргэхийг;

Дөрөв. Санхүү, ар талын газрын дарга,
хурандаа Я.Гантэмэрт

4.1. “Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас” Ерөнхий шаардлага CS 11 -0440:2020 “Гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгсэл” Ерөнхий шаардлага CS 11-0441:2020 стандартад нийцсэн ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр алба хаагч нэг бүрийг хангахад анхаарч, судалгаа хийх, худалдан авалтыг нэмэгдүүлэхийг;

4.2. Ой, хээрийн гал түймрийн голомтод олон хоног, удаан хугацаагаар ажилласан үед алба хаагчдын өдөр тутмын болон хамгаалах тусгай хувцасны эдэлгээний хугацааг харгалзахгүй нөхөн хангарт хийхийг;

4.3. Зэвсэгт хүчний болон Агаараас эрэн хайх, аврах ангийн нисдэг тэргээр тусгай үүргийн нислэг үйлдсэн тохиолдолд нислэгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд хийхийг;

Тав. Улсын нөөцийн газрын дарга,
хурандаа Ч.Цогбаяарт

5.1. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн, олон хоногоор үргэлжилсэн үед улсын нөөцөөс шаардлагатай бараа, материалын хангарт, тусlamж үзүүлэхийг;

5.2. Олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусlamжийг хүлээн авах, хуваарилах арга хэмжээ зохион байгуулахыг;

Зургаа. Ажиллагааны удирдлагын газрыг дарга,
хурандаа Б.Баянмөнхөд

6.1. Орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн судалгааг гаргах, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбаруудтай хамтарч сургалт, дадлагыг зохион байгуулж, ой, хээрийн гал түймэртэй тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг хангуулахыг;

6.2. Ой, хээрийн гал түймэрт өртсөн нэрвэгдэгчдэд эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлэх, мал амьтныг устгах, ариутгал халдвартгуйжүүлэлт хийх, нүүлгэн шилжүүлэх ажилд гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг оролцуулж удирдлагаар хангахыг;

Долоо. Мэдээлэл технологийн хэлтсийн дарга,
дэд хурандаа Д.Содномрагчаад

7.1. Гамшгийн үеийн холбоо зохион байгуулалт, түймрийн голомтод ашиглах холбооны тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж хэвийн, найдвартай ажиллагааг хангахыг;

7.2. Гамшгийн орон зайд мэдээллийн системд ой, хээрийн гал түймрийн мэдээллийн сан үүсгэж, бүртгэл хөтлөх, ой, хээрийн гал түймрийн үед ашиглах бүсчилсэн болон даргын ажлын зургийг шуурхай бэлтгэхийг;

Найм. Бүсийн төв болон төв, орон нутгийн
Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт

8.1. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.5, 17.2.2, 17.2.7, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.8, 18.2.2, 18.2.10, Галын аюулгүй байдлыг тухай хуулийн

15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.7-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг хангах, тайлагнахыг;

8.2. Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 68 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу орон нутгийн ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг нутгийн захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн оролцоотой хийхийг;

8.3. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.14, 17.2.15, 17.2.20, 18 дугаар зүйлийн 18.2.4, 18.2.5, 18.2.11, 18.2.17, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасны дагуу болон эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт, дадлага зохион байгуулах төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангуулахыг;

8.4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-д заасны дагуу сайн дурын хэсгийн дарга, жолооч, гал сөнөөгчийн мэргшүүлэх, дадлагажуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан сургалт зохион байгуулахыг;

8.5. Төв, орон нутгийн телевиз, радио, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчныг ашиглан хавар, намрын хуурайшилтын болон зуны хэт халалтын үед иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах чиглэлээр сээрэмжлүүлэг, мэдээ, мэдээлэл түгээхийг;

8.6. Онцгой байдлын ерөнхий газраас 2024 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэн, ой, хээрийн гал түймрээс хамгаалах ажиллагаанд оролцогч талуудтай харилцан ажиллагааны санамж бичиг, төлөвлөгөө байгуулж хамтарсан дадлага сургалтыг зохион байгуулахыг;

8.7. Ой, хээрийн гал түймрийн эрсдэл бүхий бүс нутагт үйл ажиллагаа эрхэлдэг айл өрх, амралтын газар, жуулчны бааз, мод, хадлан бэлтгэх бүлэг нөхөрлөл зэрэг иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу гал түймрийн улсын хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, ой, хээрийн гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангуулах;

8.8. Ой, хээрийн гал түймрийн аюултай үе буюу жил бүрийн 3 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд болон зуны хэт халалтын үед Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.18, 18 дугаар зүйлийн 18.2.12, 18.2.14- д заасныг хэрэгжүүлэн ой, хээрт үйлдвэрлэл, үйлчилгээ болон бусад үйл ажиллагаа явуулахыг хязгаарлах, зогсоох саналыг, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад танилцуулан шийдвэрлүүлж, хяналт, шалгалтын цэг, хөдөлгөөнт эргүүл томилон ажиллуулахыг;

8.9. Ой, хээрийн гал түймэр унтраах томилгоот бүрэлдэхүүн, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг, дайчлагдан ажиллах иргэдийн хувийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын

2023 оны А/191 дүгээр тушаалаар батлагдсан “Гал түймэр унтраах автомашин, техникийн тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг туршин шалгах, үйлчилгээ хийх заавар”-ын дагуу засвар үйлчилгээ хийж, аюулгүй, найдвартай ажиллагааг хангах, шаардлагатай сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэхийг;

8.10. Байнгын болон ой, хээрийн гал түймрийн үед ашиглах холбоо, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн ажиллагаа, холбооны чанар байдлыг шалгаж, бэлтгэл бэлэн байдлыг хангахыг;

8.11. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны А/346 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-ын 10.2 дахь заалтыг хэрэгжүүлэн орон нутагт байгуулагдсан Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн гал унтраах зориулалтын автомашин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, гал түймрийн дуудлага хүлээн авах зориулалт бүхий суурин болон хөдөлгөөнт холбооны хэрэгслийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх талаар анхаарч, нутгийн захирагчны байгууллагатай хамтарч ажиллахыг;

8.12. Бүсийн төвийн захирагч нар Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 6 дугаар 14-ний өдрийн 51 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын бүсийн төвийн ажиллах журам”-ын 4 дүгээр заалтыг хэрэгжүүлэн бүсийн хэмжээнд ой, хээрийн гал түймэртэй тэмцэх албаны бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, ой, хээрийн гал түймэр унтраах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хүч хэрэгслийг дайчлан гаргахыг;

8.13. Бие бүрэлдэхүүнийг ой, хээрийн гал түймрийн дуудлагаар гарч ажиллах, буцах, түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх үед Монгол Улсын Шадар Сайдын 2016 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Гал түймэр унтраах дүрэм”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/338 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм” болон Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм”-ээр сургалт зохион байгуулж, холбогдох заалтуудыг чанд мөрдөж, хэвшүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихыг;

8.14. Ой, хээрийн гал түймрийн дуудлага ирсэн даруйд Онцгой байдлын газар, хэлтсийн Эрэн хайх аврах анги, салбар, бүлгийн томилгоот зэлжийн бүрэлдэхүүнийг эхний дуудлагаар шуурхай гаргах, Эрэн хайх, аврах нэгжгүй орон нутагт Гал түймэр унтраах, аврах анги, орон нутгийн мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнийг гаргах, нэмэлтээр гарах бүлгийг богино хугацаанд бэлэн байдлыг хангуулахыг;

8.15. Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллах бүрэлдэхүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн зааварчилгаа өгч баталгаажуулан, байршил тодорхойлогч /GPS/, салхины чиг, хурд хэмжигч, сансрын холбооны утас /IRIDIUM/, богино болон хэт богино долгионы гар, суурин холбооны хэрэгсэл, байр зүйн зургаар хангаж шуурхай дуудлагаар ажиллуулахыг;

8.16. Ой, хээрийн гал түймрийн мэдээ, мэдээллийг хүлээн авсан албан тушаалтан, бүсийн төвийн зохицуулагч нар цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын ой, хээрийн гал түймрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт цаг алдалгүй шуурхай мэдээлэхийг;

8.17. Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д заасныг хэрэгжүүлэн Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам”-ын дагуу экологийн болон эд хөрөнгөд учирсан хохирол, түймрийг унтраахад гарсан зардлыг хуулийн хугацаанд, үнэн зөв тооцох хяналт тавихад орон нутгийн Байгаль орчны газартай хамтарч ажиллахыг;

Ёс. Үндэсний аврах бригадын захирагч,
хурандаа Б.Мандахгэрэлд

9.1. Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллах бүрэлдэхүүнийг томилгоожуулж, албан хаагчдын болон автомашин техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлтгэл бэлэн байдал, аюулгүй найдвартай ажиллагааг ханггуулж, шаардлагатай сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэхийг;

9.2 Ой, хээрийн гал түймэр унтраах томилгоот бүрэлдэхүүн, шүхрийн зааварлагч, шүхэрчин гал сөнөөгчдийн шүхрийн буултын дадлагыг зохион байгуулахыг;

9.3. Бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймэр унтраах, хөдөлмөрийн болон замын хөдөлгөөн, агаарын хөлгөөр зорчих, ачаа бараа тээвэрлэх үеийн аюулгүй байдлыг хангах сургалт, дадлага зохион байгуулж, томилгоот бүрэлдэхүүнийг нисгэгчгүй нисэх төхөөрөмж, байршил тодорхойлогч /GPS/, салхины чиг, хурд хэмжигч, сансрын холбооны утас /IRIDIUM/, богино болон хэт богино долгионы гар, суурин холбооны хэрэгсэл, байр зүйн зургаар хангахыг;

9.4. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд оролцох томилгоот бүрэлдэхүүний хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн ханггуулж, холбогдох дүрэм, журмын дагуу зааварчилгаа өгөхийг;

Арав. Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангийн захирагч,
хурандаа Т.Мөнхдоржид

10.1. Нисдэг тэрэгний техникийн бэлтгэл, бэлэн байдлыг ханггуулж, хүн хүч, техник хэрэгслийг ой, хээрийн гал түймрийн голомтод шуурхай хүргэхийг;

10.2. Ой, хээрийн гал түймрийн эрсдэл бүхий, алслагдсан аймаг, сумдад нисдэг тэрэг цэнэглэх шатахууны нөөц бүрдүүлэх, хүргэх ажлыг зохион байгуулж, бэлэн байдлыг хангахыг;

10.3. Ой, хээрийн бүсэд буулт хийх, хөөрөх үеийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн ханггуулж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль бусад холбогдон гарсан дүрэм, журмыг судлуулан, зааварчилгаа өгөхийг;

10.4. Бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймэр унтраах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хангах, газар орны нөхцөл байдлыг үнэлэх, нисгэгчдийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, дадлага зохион байгуулахыг.

Арван нэг. Жаргалант сэргээн засах төв 113 дугаар ангийн захирагч,
хурандаа Д.Жаргалмөнхөд

11.1. Бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймэр унтраах, хөдөлмөрийн болон замын хөдөлгөөн аюулгүй байдлыг хангах, гал түймэрт нэрвэгдэгчдэд үзүүлэх анхны болон эмнэлгийн тусламж үзүүлэх сургалт, дадлага зохион байгуулахыг;

11.2. Шаардлагатай тохиолдолд ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх

зорилгоор эмнэлгийн тусгай хэрэгсэлтэй эмч томилон ажиллуулах томилгоо хийх, бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн зааварчилгаа өгч баталгаажуулахыг;

11.3. Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд олон хоногоор үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4-т заасан сэтгэл зүйн болон бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамруулахыг;

Арван хоёр. Ар талын 115 дугаар ангийн захирагч,
хурандаа Л.Баярсайханд

12.1. Автомашин, техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, хүн хүч, техник хэрэгслийг ой, хээрийн гал түймрийн голомтод шуурхай хүргэхийг;

12.2. Бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймэр унтраах, хөдөлмөрийн болон замын хөдөлгөөн аюулгүй байдлыг хангах сургалт, дадлага зохион байгуулахыг;

12.3. Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх жолооч болон автомашин техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, засвар үйлчилгээг тогтмол хийж, шаардлагатай сэлбэг, хэрэгсэл, шатах, тослох материалын нөөц бүрдүүлэхийг;

12.4. Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллах алба хаагч нэг бүрийг ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, хувцас хэрэгслийн эдэлгээ, элэгдлийг тооцож тухай бүр нөхөн хангаль хийж байхыг;

Арван гурав. Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв
119 дугаар ангийн захирагч, хурандаа А.Алтанбаганад

13.1. Ой, хээрийн гал түймрийн мэдээ, мэдээллийг холбогдох албан тушаалтанд шуурхай дамжуулахыг;

13.2. Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүлэг, бүсийн шуурхай удирдлагын төвтэй тогтмол холбоонд орох, нэмэлтээр ажиллах бүлгүүдэд тодотгол хийж, бэлэн байдлыг хангуулахыг;

13.3. Онцгой байдлын өрөнхий газрын даргын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн А/160 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн гал түймрийн мэдээллийг Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагад дамжуулах заавар”-ын дагуу хөрш орнуудтай мэдээлэл солилцож, удирдлагыг мэдээллээр шуурхай хангахыг;

Албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг 6 дугаар сарын 14, 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Гал түймэртэй тэмцэх газарт ирүүлэхийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН